



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/199

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16 дахь заалт, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “ШУТИС-ийн Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- “ШУТИС-ийн Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг нийт багш, ажилтнуудад танилцуулах, мөрдөж хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг холбогдох захиргааны нэгжийн удирдлага, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нарт даалгасугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Ректорын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” А/64, 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/105, 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/188, 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/188, ШУТИС-ийн Захирлын 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/134 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.
- Энэхүү тушаалыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

РЕКТОР



Т. НАМНАН

367041145



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

Журмын төсөл

	Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам ШУТИС-СҮ-ЖУ	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2014 2025 6
---	--	--	-------------------

ШУТИС-ИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ



ШУТЫС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ.....	5
ЗУРГАА. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	9
НАЙМ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
ЕС. ОЮУТНЫ ХИЧЭЭЛ СОНГОЛТ	13
АРАВ. ОЮУТНЫ МЭДЛЭГИЙН ҮНЭЛГЭЭ.....	14
АРВАН НЭГ. ОЮУТНЫ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН	21
АРВАН ХОЁР. ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ.....	23
АРВАН ГУРАВ. ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	25



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журмыг үндэслэн Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль(цаашид ШУТИС гэх)-ийн бакалаврын зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Энэхүү журмаар зохицуулагдахгүй үйл ажиллагааг бусад холбогдох дүрэм, журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. ШУТИС-ийн багш, оюутан болон сургалтад оролцогч бусад талууд энэхүү журмыг мөрдөнө.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын ерөнхий хууль
- 3.2. Дээд боловсролын тухай хууль
- 3.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам
- 3.4. Дээд боловсролын сургалтын агуулгыг баг цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам
- 3.5. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. Боловсролын түвшин гэж сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг;
- 4.2. Гүйцэтгэлийн үнэлгээ гэж оюутны суралцахуйн үр дүнг тодорхой шалгуур, нотлох баримтад үндэслэн магадлах үйл явцыг;
- 4.3. Дадлагын хичээл гэж оюутны онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлэх, дадал эзэмшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бие даан болон багаар ажиллаж чадварт сургах зорилготой сургалтын хэлбэрийг;
- 4.4. Зэргийн бус сургалт гэж иргэнд тодорхой чиглэлээр мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж олгох, боловсролын зэрэг олгохгүй сургалтыг;
- 4.5. Өмнөх холбоо хичээл гэж тодорхой хичээлийг судлахаас өмнө судалсан байвал зохих хичээлийг;
- 4.6. Суралцагч оюутан (цаашид “оюутан” гэх) гэж дэд бакалавр болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагчийг;
- 4.7. Сургалтын хөтөлбөр гэж Хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага төлөвшил, сургалтын арга зүй, үнэлгээ сайжруулалтын төлөвлөлт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, элсэгч, төгсөгчид тавигдах шаардлагыг тусгасан цогц баримт бичгийг;



ШУТЫС-ийн ректорын 2025 болон 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 4.8. Сургалтын төлөвлөгөө гэж хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл болон судлах хичээлийн код, нэр, харгалзах багц цаг, өмнөх холбоо улирал зэрэг мэдээллийг агуулсан баримт бичгийг;
- 4.9. Сургалтын үйл ажиллагаа гэж лекц, семинар, практик, лаборатори гэх мэт хэлбэрээр хичээлийг бэлтгэх, хүргэх, зөвлөгөө өгөх, хэлэлцүүлэг хийх, явцын болон улирлын шалгалт, даалгавар, бие даалтын ажлыг шалгаж дүгнэх зэрэг цогц үйл ажиллагаагаар багш болон суралцагчийн хооронд үүсэх харилцааг;
- 4.10. Сургалтын орчин гэж сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэлзүйн нөхцөл, сурах, сургах харилцааг;
- 4.11. Сургалтын зээл гэж сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцагчид олгох мөнгөн хөрөнгийг;
- 4.12. Танхымын сургалт гэж урьдчилан боловсруулж баталсан хичээлийн хуваарийн дагуу зөвхөн сургалтын анги, танхимд зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;
- 4.13. Танхымын бус сургалт гэж сургалтын удирдлага мэдээллийн систем (LMS), цахим сургалтын платформ ашиглан бодит хугацааны (online) болон бодит хугацааны бус (offline) хэлбэрээр зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;
- 4.14. Төслийн хичээл гэж суралцагч багаар эсвэл ганцаарчилсан байдлаар асуудал шийдвэрлэх төсөл хэлбэрийн даалгавар гүйцэтгэж хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа практик хэрэглээ болгох сургалтын хэлбэрийг; Энэ нь төсөлд суурилсан сургалтын хэлбэрээр зохион байгуулагдах хичээл байх бөгөөд суралцагч 1-р курсээсээ эхлэн хичээлийн жил бүр үе шаттайгаар судлахаар төлөвлөгдсөн байж болно.
- 4.15. Улирлын шалгалт гэж тухайн хичээлийг судалж дууссаны дараа улирлын эцэст суралцагч хичээлийн хөтөлбөрт заасан мэдлэг, ур чадвар, хандлагыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх үйл ажиллагааг;
- 4.16. Үнэлгээний дундаж оноо гэж суралцагчийн улирлын болон суралцсан хугацааны сурлагын чанаарын түвшнийг нийт оноогоор тооцсон үзүүлэлтийг;
- 4.17. Үнэлгээний голч дүн (GPA) гэж суралцагчийн улирлын болон суралцсан хугацааны сурлагын чанаарын түвшнийг тоогоор илэрхийлсэн дүнгээр тооцсон үзүүлэлтийг;
- 4.18. Хичээлийн цаг гэж байгалийн цагийн 50 минутыг; Хоёр цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно;
- 4.19. Хичээлийн 1 кредит гэж оюутан тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг эзэмших зорилгоор хуваарьт цагаар хичээллэх болон бие даан суралцахад зарцуулах 48 цагийг;
- 4.20. Хичээлийн хөтөлбөр гэж Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн үндсэн мэдээлэл, суралцахуйн үр дүнгүүд, сургалтын арга зүй, үнэлгээний аргачлал болон бусад холбогдох мэдээлэл агуулсан баримт бичгийг;
- 4.21. Хичээлийн код гэж хичээл хариуцсан сургууль, хичээлийн нэр (хариуцах тэнхим), төрөл, түвшин илэрхийлсэн дугаарлалтыг;
- 4.22. Хичээлийн суралцахуйн үр дүн гэж оюутан тухайн хичээлээр эзэмшсэн байх цогц чадамжийн тодорхойлолтыг;




ШУТЫС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 4.23. Хичээлийн улирал (цаашид “улирал” гэх) гэж хичээл хоорондын хамааралтай байдал, залгамж чанартай уялдуулан сургалтын үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулахын тулд тодорхой үечлэлтэйгээр тодорхойлсон хугацааг;
- 4.24. Хичээл дүйцүүлэн тооцох гэж өмнө судалсан хичээлийн суралцахуйн үр дүн, кредит, үнэлгээг суралцах хөтөлбөрийн хичээлийн суралцахуйн үр дүн, кредит, үнэлгээтэй дүйцүүлэн тооцохыг;
- 4.25. Хичээл солилцооны гэрээ гэж сургуулиуд хөтөлбөр/хичээлийн суралцахуйн үр дүн, үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрч, аль нэг сургуульдаа судлах боломжийг олгосон, хичээлийн жагсаалт бүхий баримт бичгийг;
- 4.26. Хосолсон сургалт гэж танхимиын сургалт, танхимиын бус сургалтыг тодорхой хувь харьцаагаар хослуулсан зохион байгуулах сургалтын үйл ажиллагааг;
- 4.27. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасан комисс хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон суралцагчийг;
- 4.28. Хүндэтгэн үзэх шалтгаан гэж хүнд өвчтэй, эмчилгээ хийлгэж байгаа, өвчтөн асарсан, (эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд, ава, ээж, төрсөн ах, эгч, дүү), жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, нас барсан, нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан, нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон, галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл (усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт)-ийг;
- 4.29. Элсэлтийн шалгалт гэж Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэн суралцагчид суралцахад шаардагдах сурх ярхийн чадвар, мэдлэгийн түвшин тогтоо шалгалтыг;
- 4.30. Явцын шалгалт гэж хичээлийн хөтөлбөрийг оюутан хэрхэн эзэмшиж буйг хэмжих, ажиллах шаардлагатай хэсгийг тодорхойлох зорилготой улирлын дунд явагдах, үнэлэх үйл ажиллагааг;
- 4.31. Явцын оноо гэж оюутны суралцахуйн үйл явц, үр дүнг хянах, улмаар сайжруулах зорилго бүхий үнэлгээг;

ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

- 5.1. Сургалт хариуцсан захиргааны нэгж нь:
 - 5.1.1. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой бодлого, дүрэм, журам боловсруулж, шийдвэрийн хэрэгжилтийг хянах;
 - 5.1.2. Бүх түвшний хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 5.1.3. Бүх түвшний сургалтын үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохион байгуулалтад хяналт тавих;
 - 5.1.4. Бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан, төгсөлтийн баримт бичгийг хэвлэх, албажуулах, архивлах;
 - 5.1.5. Сургалттай холбоотой тоон мэдээлэл, холбогдох судалгаа хийх, дүн шинжилгээ хийх, тайлан гаргах.
- 5.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж нь:
 - 5.2.1. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, шийдвэрийг хэрэгжүүлэх;



ШУТЫС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 5.2.2. Бүх түвшний сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- 5.2.3. Бүх түвшний суралцагчийн бүртгэл, үнэлгээтэй холбоотой асуудлыг хариуцан зохион байгуулах;
- 5.2.4. Профессор, багшийн сургалтын үйл ажиллагаа, суралцагчийн хичээлийн оролцоонд хяналт тавих;
- 5.2.5. Оюутны суралцагчийн үйл ажиллагааг дэмжиж, зөвлөгөө мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэх;
- 5.2.6. Сургалттай холбоотой тоон мэдээлэл, тайлан гаргах, холбогдох судалгаанд дүн шинжилгээ хийх.
- 5.3. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхим нь:
 - 5.3.1. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 5.3.2. Сургалтын хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, сургалт явуулах, хөтөлбөрийн үр дүн, чанарт байнгын дүн шинжилгээ, өөрийн үнэлгээ хийж, дотоодод болон олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх;
 - 5.3.3. Суралцагчдын суралцах таатай орчин болон сургалтын иж бүрэн материалыар хангах, мэргэжлийн ном, суралцагчийн бичиг, гарын авлага, заавар боловсруулах;
 - 5.3.4. Оюутны авьяас чадварыг нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, мэргэжлийн уралдаан, олимпиад, олон нийтийн ажил, дугуйлан клубийн үйл ажиллагааг дэмжин ажиллах;
 - 5.3.5. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээ, тайлан гаргах.
- 5.4. Мэдээллийн технологи хариуцсан нэгж нь:
 - 5.4.1. Удирдлага мэдээллийн системийг сургалтын үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлж сайжруулах;
 - 5.4.2. Удирдлага мэдээллийн системийн хэвийн ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах.
- 5.5. Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан нэгж нь:
 - 5.5.1. Сургалттай холбоотой санхүүгийн үйлчилгээг хариуцах;
 - 5.5.2. Бүрэлдэхүүн сургууль хоорондын санхүүгийн тооцоо хийх;
 - 5.5.3. Холбогдох мэдээ, тайлан гаргах.
- 5.6. Оюутны үйлчилгээний нэгж нь:
 - 5.6.1. Сургалтын төлбөрийн зээл, тусламж, тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгт хамрагдах үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 5.6.2. Оюутны эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулах, клуб, олон нийтийн үйл ажиллагаа, хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээг холбогдох нэгжтэй хамтран хэрэгжүүлэх;
 - 5.6.3. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх;
 - 5.6.4. Холбогдох мэдээ, тайлан гаргах.
- 5.7. Эрүүл мэндийн үйлчилгээний нэгж нь:



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 5.7.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх;
 - 5.7.2. Оюутанд эрүүл мэндийн даатгал, түүний ач холбогдол хэрхэн хамрагдах талаар танилцуулга, мэдээлэл хүргэх;
 - 5.7.3. Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах;
 - 5.7.4. Холбогдох мэдээ, тайлан гаргах.
- 5.8. Номын сангийн үйлчилгээний нэгж нь:
- 5.8.1. Оюутанд номын сангийн үйлчилгээг (уншлагын танхимд, цахим хэлбэрээр, гэрээр унших гэх мэт) үзүүлэх;
 - 5.8.2. Холбогдох мэдээ, тайлан гаргах.
- 5.9. Байр ашиглалт, дэд бүтцийн хэвийн ажиллагаа хариуцсан нэгж нь:
- 5.9.1. Сургалтыг хэвийн явуулах орчин, дэд бүтцээр хангах, засвар үйлчилгээг тухай бүр хийх, хяналт тавих.

ЗУРГАА. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 6.1. ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг Сургалтын асуудал эрхэлсэн проректор, Сургалт хариуцсан захиргааны нэгж болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж, тэнхим удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 6.2. Бакалаврын сургалтын үйл ажиллагааг ШУТИС-ийн Ректорын баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг үндэслэн "Сургалтын нэгдсэн хуанли"-ийн дагуу хичээлийн жил болон улирлаар төлөвлөн зохион байгуулна.
- 6.3. Хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд намар, хавар гэсэн үндсэн улирал болон өвөл, зуны нэмэлт улиралтай байна.
- 6.4. Намар, хаврын үндсэн улирал нь хичээлтэй танилцах, сонголт хийх, хичээллэх, улирлын шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх гэсэн бүтэцтэй байна.
- 6.5. Хөгжлийн бэрхшээлтэй (онцлог хэрэгцээтэй) оюутанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно. Оюутны хүсэлтийн дагуу шаардлагатай зохицуулалт (тусгай хэрэгсэл зэрэг) хийж болох ба бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж шийдвэрлэнэ.
- 6.6. Сургалтыг танхимиын, танхимиын бус, хосолсон хэлбэрээр зохион байгуулж болох ба сургалтын төрөл, үргэлжлэх хугацаанаас хамааруулж хүснэгт 6.1-д үзүүлсэн төрлүүдээр төлөвлөж болно. Тэнхим нь сургалтын төрлөөс үл хамаарч сургалтын чанар, үйл ажиллагааг хэвийн явуулах анхаарч хяналт тавьж ажиллана.

Хүснэгт 6.1. Сургалтын төрөл, хэлбэр, хугацаа

Д/д	Сургалтын				Элсэгчдэд тавигдах шаардлага
	Хэлбэр	Төрөл	Хугацаа /7 хоног/	Зохион байгуулалт	
1	Танхимиын	Үндсэн өдрийн	16	Хичээлийн бүрэн агуулгыг танхимд суралцана.	Элсэлтийн журмын шаардлага хангасан, бүрэн дунд эсвэл техникийн болон бакалаврын боловсролтой иргэн;



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

		Зэргийн бус			Бүрэн дунд боловсролтой иргэн; бусад их сургуульд суралцаж буй оюутан; төгсөгчид; ажиллаж байгаа иргэн;
		Эчнээ	8	Хичээлийн агуулгын 60 хувийг 6 долоо хоногт танхимд заахаас гадна 2 долоо хоногт оюутны бие даан суралцсан үр дүнг дүгнэх, шалгалт авах зэрэг үйл ажиллагаа багтана.	Бакалаврын болон тухайн мэргэжлийн чиглэлийн техникийн боловсролтой иргэн
		Модуль	8	Тухайн улиралд судлах хичээлүүдийг 2 багцад хуваан тус бүрийг 8 долоо хоногт судална.	Элсэлтийн журмын шаардлага хангасан, бүрэн дунд эсвэл техникийн болон бакалаврын боловсролтой иргэн;
		Өвөл/зун	4/6	Хуанлид заасан хугацаанд 1-2 хичээл судална.	Элсэлтийн журмын шаардлага хангасан, бүрэн дунд эсвэл техникийн болон бакалаврын боловсролтой өвлүүн элсэгч; Тухайн хичээлийг давтан судлах оюутан
		Гарагийн	16	Тодорхой гарагуудад хичээлийн бүрэн агуулгыг суралцана.	Бүрэн дунд боловсролтой, элсэлтийн журмын тусгай шаардлага хангасан; Бакалаврын болон тухайн мэргэжлийн чиглэлийн техникийн боловсролтой иргэн
2	Танхимын бус	Ганцаарчилсан	16	Хичээлийн бүрэн агуулгыг суралцана.	Онцлог хэрэгцээ шаардсан оюутан; Ганцаарчилсан хэлбэрээр суралцах хүсэлт гаргасан оюутан.
		Өвөл/зун	4/6	Хуанлид заасан хугацаанд	Тухайн хичээлийг давтан судлах оюутан
		Цахим сургалт	16 хүртэл	Хичээлийн бүрэн агуулгыг суралцана.	Бүх хэлбэрийн элсэгчид хамаарна
3	Хосолсон сургалт	Цахим-танхим хосолсон	12	Хичээлийн 16 долоо хоногийн бүрэн агуулгыг 8 долоо хоногт цахимаар, 4 долоо хоног танхимаар судална.	Бакалаврын болон тухайн мэргэжлийн чиглэлийн техникийн боловсролтой иргэн
		Ганцаарчилсан			Онцлог хэрэгцээ шаардсан оюутан; Ганцаарчилсан хэлбэрээр суралцах хүсэлт гаргасан оюутан.
		Модуль	8	Тухайн улиралд судлах хичээлүүдийг 2 багцад хуваан тус бүрийг 8 долоо хоногт судална.	Элсэлтийн журмын шаардлага хангасан, бүрэн дунд эсвэл техникийн болон бакалаврын боловсролтой иргэн;



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

		Гарагийн	16	Тодорхой гарагуудад хичээлийн бүрэн агуулгыг судална.	Бүрэн дунд боловсролтой, элсэлтийн журмын тусгай шаардлага хангасан; Бакалаврын болон тухайн мэргэжлийн чиглэлийн техникийн боловсролтой иргэн
--	--	----------	----	---	--

- 6.7. Үндсэн өдрийн сургалтаас бусад төрлийн сургалтыг сургалт хариуцсан захиргааны нэгжээс гаргасан удирдамжийг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж зохион байгуулна.
- 6.8. Бусад их сургуультай хамтран дундын бүртгэл, мэдээллийн систем үүсгэн зэргийн бус сургалт зохион байгуулж болно.
- 6.9. Өвөл, зуны сургалтыг сургалт хариуцсан захиргааны нэгж болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж хамтран зохион байгуулна. Сургалтын төлөвлөгөөнд тусгайлан тэмдэглэсэн (*) болон мэргэших хичээлээр өвөл, зуны сургалт зохион байгуулахгүй.
- 6.10. Сургалт, дадлага, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн лаборатори, дадлагажих газрыг түшиглэн явуулж болно.
- 6.11. Сургалтын хөтөлбөр, эсвэл тухайн хичээлийг Монгол хэлээс гадна гадаад хэлээр хэрэгжүүлж болно.
- 6.12. Нэг улиралд олон оюутан судалдаг хичээлийн хувьд оюутан хэд хэдэн багшаас сонгон суралцах боломж бүрдүүлсэн байна. Цөөн оюутантай хичээлийн хувьд тухайн улиралд зөвхөн нэг багш заахаар төлөвлөлт хийгдэж болно.
- 6.13. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж нь тэнхимийн саналыг үндэслэн хуанлид заасан хугацаанд тухайн улиралд заагдах хичээл, заах багшийн нэр, анги танхим, хичээллэх цаг бүхий хичээлийн хуваарийг гаргаж сургуулийн захирал батална.

ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 7.1. Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх үйл ажиллагааг хичээлийн жилийн намар, хаврын улиралд 2 удаа цахимаар зохион байгуулна.
- 7.2. Бакалаврын элсэлтийн үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулах ба журмыг хичээлийн жил бүр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан оюутан элсүүлэх нийтлэг журамд нийцүүлэн сургалт хариуцсан захиргааны нэгж боловсруулж, батлуулна.
- 7.3. Гадаад иргэнийг "ШУТИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам"-ын дагуу элсүүлэн суралцуулна.

НАЙМ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ

- 8.1. ШУТИС-ийн Ректорын баталсан, төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 8.2. Оюутан нь сургалтын хөтөлбөрт тусгасан хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг сургалтын хугацаанд эзэмшинэ.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 8.3. Сургалтын хөтөлбөр нь үндсэн сургалтын хөтөлбөр, өөр чиглэлээр зэрэгцэн суралцах хавсарга хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээтэй дотоод, гадаадын эрх бүхий сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан хөтөлбөр хэлбэртэй байна.
- 8.4. Сургалтын төлөвлөгөө нь харилцан уялдаатай ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших(мэргшүүлэх хичээл, төсөл, дадлага, дипломын төсөл) хэсэгтэй, хэсэг бүрд заавал ба сонгон судлах хичээлтэй байх ба хүснэгт 8.1-т үзүүлсэн жишиг бүтэцтэй байна. Оюутныг суралцах үйл ажиллагаагаа зөв төлөвлөхөд зориулж "Оюутанд санал болгох төлөвлөгөө" -г гарган оюутанд хүргэнэ.

Хүснэгт 8.1. Сургалтын төлөвлөгөөний жишиг бүтэц

Сургалтын төлөвлөгөөний агуулга	Судлах хэлбэр	Хичээлийн кодын ангилал		Хичээлийн төрөл	Тайлбар	
		үндсэн	дэд			
Ерөнхий суурь хичээл:	Заавал	100-199		Үндсэн	Шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, хандлага төлөвшил эзэмшүүлэх агуулга бүхий хичээл	
	Сонгон				Суралцах чиглэлийн шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх агуулга бүхий хичээл	
Мэргэжлийн суурь хичээл:	Заавал	200-299		300-349 350-359 360-369 370-379	Тухайн салбар чиглэлийн мэргэжлийн мэдлэг, чадвар, арга технологи эзэмшүүлэх агуулга бүхий хичээл, дадлага, төсөл байна. Дадлагын зарим хичээлийг хөтөлбөрийн онцлогоос хамаарч мэргэжлийн суурь хэсэгт төлөвлөж болно.	
	Сонгон			300-499 380-499	Бакалаврын дипломын төсөл Нөөц дугаарлалт	
Нээлттэй сонгон судлах хичээл	Сонгон	Тухайн хөтөлбөрөөс ШУТИС-ийн бусад хөтөлбөрийн оюутанд санал болгох хичээл байх ба оюутан өөрийн сонирхлын дагуу нэмж судалсан тохиолдолд дипломын хавсралтад нэмэлтээр бичиж болно.				
Заавал судлах нэмэлт хичээлүүд	Заавал /Сонгон	Суралцагчийн ёс зүй, хандлага төлөвшил, суралцах чадварыг хөгжүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн хичээл байх ба оюутан суралцах хугацаандaa дурын улиралд судлахаар төлөвлөнө.				

- 8.5. Хичээлийн хөтөлбөр нь тухайн хичээлийн үндсэн мэдээлэл, суралцахуйн үр дүн, сургалтын арга зүй, үнэлгээний аргачлал болон бусад холбогдох мэдээлэл агуулсан байх ба оюутан хичээл сонголт хийхээс өмнө удирдлага мэдээллийн системээр дамжуулж хичээлийн хөтөлбөртэй танилцсан байна.



ШУТИС-ийн ректорын 2025-оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 8.6. Агуулгын багтаамжаас хамаарч хэд хэдэн улирал дамнан судлах хичээлийг өмнөх холбоо бүхий хичээлүүдэд хувааж, залгамж чанарыг илэрхийлсэн нэр, кредит, код оноосон байна. Энэ тохиолдолд оюутан өмнөх холбоо хичээлийг үнэлүүлсний дараа залгамж хичээлийг судлах эрх үүснэ.
- 8.7. Тухайн хичээлийн 1 кредит нь оюутны 48 цагийн хөдөлмөрийг илэрхийлэх ба хичээлийн хэлбэр, түвшнээс хамаарч хүснэгт 8.2-д үзүүлсэн задаргаатай байна.

Хүснэгт 8.2. Хичээлийн 1 кредитийн задаргаа

Хөтөлбөрийн түвшин	Хичээлийн хэлбэр		
	Лекц	Семинар/Практик	Лаборатори
	1 кредит (Хичээлийн цаг + Суралцагчийн бие даан суралцах цаг)		
Бакалавр	16+32	32+16	48+0 эсвэл 32+16

- 8.8. Хичээлийн суралцахуйн үр дүнгээс хамаарч хичээлийн хүргэх хэлбэр нь дан лекц, лекц/семинар, лекц/лаборатори, лекц/семинар/лаборатори, дан семинар, практик эсвэл лаборатори хэлбэртэй байна.
- 8.9. Дадлагын хичээлийн 1 кредит нь дадлагын байранд суралцах 32 цаг, бие даан суралцах 16 цаг байх ба оюутан өдөрт 4-аас доошгүй цаг ажлын байранд, 2 цаг бие даан суралцана гэж үзэж дадлагын үргэлжлэх хугацааг тогтооно.
- 8.10. Дадлагын хичээлийг удирдамжийн дагуу бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхим хариуцан зохион байгуулна.
- 8.11. Танилцах дадлага нь хөтөлбөрийн онцлогоос хамаарч 1-3 хүртэл кредиттэй байх ба өвөл, зуны улиралд зохион байгуулна.
- 8.12. Үйлдвэрлэлийн дадлага нь хөтөлбөрийн онцлогоос хамаарч үйлдвэрлэлийн, хээрийн, орчуулгын, мэргэжлийн гэх мэт төрлүүдтэй байх ба өвөл, зуны улиралд зохион байгуулна.
- 8.13. Хөтөлбөрийн онцлогоос хамаарч үйлдвэрлэлийн дадлагыг ажлын байранд суурилсан сургалтын хэлбэрээр 20 хүртэл кредитээр төлөвлөн үндсэн улиралд зохион байгуулж болно.
- 8.14. Дипломын өмнөх дадлагыг хөтөлбөрийн онцлогоос хамаарч 1-3 хүртэл кредитээр төлөвлөх ба үндсэн улиралд зохион байгуулна.
- 8.15. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан төслийн хичээлийг практикийн хичээл хэлбэрээр хуваарьт тусгах ба 1 кредит нь танхимд суралцах 32 цаг, бие даан суралцах 16 цаг, байна.
- 8.16. Оюутан бакалаврын дипломын төслийг багшийн удирдлагаар 2 хүртэл улирлын турш гүйцэтгэхээр төлөвлөнө.
- 8.17. Ерөнхий суурь, мэргэжлийн суурийн хичээлийг бүрэн судалсан, 2.50 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй оюутан магистрын түвшний 12 хүртэлх кредит цагийн хичээлийг нэмэлтээр судалж болох ба магистрт элсэн суралцах тохиолдолд дүйцүүлэн тооцуулна.
- 8.18. Хөтөлбөрийн хорооны шийдвэрээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийг мөрдөж эхлэх хичээлийн жил, хамаарах оюутны курсыг нарийвчлан тогтоож өгнө.



ШУТИС-ийн ректорын 2025 болон 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

ХАВСАРГА ХӨТӨЛБӨР

- 8.19. Оюутан үндсэн хөтөлбөрийн зэрэгцээ өөрийн сонирхсон чиглэлээр хавсарга хөтөлбөрөөр суралцаж болно.
- 8.20. Хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь мэргэжлийн суурь, мэргэших түвшний заавал болон сонгон судлах хичээлтэй байх ба суралцагч 24-өөс багагүй кредитийн хичээл судална.
- 8.21. Үндсэн хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийг бүрэн судалсан, суралцсан хугацааны үнэлгээний голч дүн 2.0 ба түүнээс дээш байгаа оюутан хавсарга хөтөлбөрөөр суралцах хүсэлтээ хичээл сонголт 1-ээс өмнө хөтөлбөр хариуцаж буй бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид гаргах ба дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - Өргөдлийн маягт
 - Суралцсан хугацааны дүнгийн баталгаажуулсан хуудас
- 8.22. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж оюутны хүсэлтийг хөтөлбөр хариуцсан тэнхимд танилцуулж зөвшөөрсөн тохиолдолд захирлын тушаалаар баталгаажуулж, сургалтын удирдлага мэдээллийн системд дараагийн улирлаас эхлэн суралцуулах эрх нээнэ.
- 8.23. Оюутан үндсэн хөтөлбөрийн зэрэгцээ хоёр хүртэл хавсарга хөтөлбөрт зэрэг суралцаж болно. Хавсарга хөтөлбөрөөр суралцаж буй оюутан үргэлжлүүлэн хос хөтөлбөрөөр суралцах хүсэлт гаргаж болно.
- 8.24. Оюутан хавсарга хөтөлбөрөөр төгссөн тохиолдолд тусад нь боловсролын зэрэг олгохгүй, хавсарга хөтөлбөрийн гэрчилгээ олгох ба энэ нь үндсэн хөтөлбөрийн төгсөлтийн бичиг баримтын хамт хүчинтэй байна.

ХОС МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИХ (ХОС ХӨТӨЛБӨР)

- 8.25. Оюутан суралцах хугацаагаа хэмнэх, боловсролын давхар зэрэгтэй төгсөх, цаашид ажлын байранд хөрвөн ажиллах зорилгоор үндсэн хөтөлбөрөөр суралцахын зэрэгцээ өөрийн сонирхсон бусад чиглэлээр хос мэргэжил эзэмшиж болно.
- 8.26. Оюутны суралцах хугацаандaa цуглувансийн нийт кредит 70-аас багагүй, 2.70 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй бол тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид дараах бичиг баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргана. Үүнд:
 - Өргөдлийн маягт
 - Суралцсан хугацааны дүнгийн баталгаажуулсан хуудас
 - Өөрийн суралцаж буй хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө
- 8.27. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжийн дарга оюутны хүсэлтийг хүлээн авч, хөтөлбөр хариуцсан тэнхимиийн эрхлэгчтэй зөвлөлдөн оюутанд тухайн хөтөлбөрөөр суралцах боломжтой эсэх тухай хариу өгнө.
- 8.28. Оюутан сургалтын нэгдсэн хуанлийн дагуу "Хичээл сонголт 2" явагдаж дууссанаас хойш хүсэлт гаргасан, тухайн хөтөлбөрт суралцаж буй оюутны тоо их, эсвэл уг хөтөлбөрөөр сургалт явагдахгүй байгаа зэрэг тохиолдолд сургалт хариуцсан нэгжийн дарга татгалзсан хариу өгнө.
- 8.29. Хос хөтөлбөрөөр суралцах зөвшөөрөл авсан оюутны бичиг баримтыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж нэгтгэн, сургалт хариуцсан захиргааны



нэгжид хүргүүлнэ. Сургалт хариуцсан захиргааны нэгж эцэслэн шийдвэрлэж, Ректорын тушаалаар баталгаажуулна.

- 8.30. Хос хөтөлбөрөөр суралцах зөвшөөрөл авсан оюутан суралцах гэрээ байгуулах ба хөтөлбөр хариуцсан тэнхимийн эрхлэгч оюутны судалсан хичээл, сургалтын төлөвлөгөөг үндэслэн хичээлийг урьдчилан дүйцүүлж, хос хөтөлбөрөөр суралцах төлөвлөгөөг зөвлөнө.
- 8.31. Хос хөтөлбөрөөр суралцаж буй оюутан үндсэн хөтөлбөрөөр төгссөний дараа төгсөлтийн бичиг баримтыг үндэслэн хичээл дүйцүүлэлт хийх ба 2 дах мэргэжил эзэмших сургалтын төлөвлөгөөний дүйцүүлээгүй хичээлүүдийг бүрэн судалж төгсөх болзол хангана.

ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

- 8.32. Дотоод, гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрт элсэлтийн журмын дагуу элсэн суралцана.
- 8.33. Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрөөр суралцах тохиолдолд 2 их сургуулийн хамтран боловсруулсан нэгдсэн сургалтын төлөвлөгөөний дагуу үндсэн хөтөлбөрийн хичээлээс гадна гадаад хэлний багц хичээл судална.
- 8.34. Оюутан олон улсын шалгалтын батламжтай тохиолдолд гадаад хэлний хичээлийг дүйцүүлж болно.
- 8.35. Хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй сургуулиас тавьсан шаардлагыг хангасан оюутан гадаадын их сургуульд дэвшин суралцах бөгөөд сургалтын төлбөр, тэтгэлэг, бусад нөхцөлийг тусгасан нэмэлт гэрээ байгуулна.
- 8.36. Гадаадын их сургуультай хамтарсан давхар зэрэг олгох хөтөлбөрийн төгсөгчид бакалаврын төгсөлтийн журмын дагуу ШУТИС-ийн диплом олгоно.
- 8.37. Дотоодын их сургуультай хамтарсан хөтөлбөрөөр суралцах тохиолдолд 2 их сургуулийн хамтран боловсруулсан сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл судлах ба шаардлага хангасан төгсөгчид хамтарсан зэрэг олгох буюу зөвхөн нэг сургуулийн диплом олгоно.
- 8.38. Хамтарсан хөтөлбөрийн оюутны хамтрагч сургуульд шилжин суралцах үйл ажиллагааг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

ЕС. ОЮУТНЫ ХИЧЭЭЛ СОНГОЛТ

- 9.1. Оюутан хичээл сонголтоо урьдчилсан захиалга (Хичээл сонголт 1) буюу хичээл сонгох, хичээлийн цаг, багш сонгох (Хичээл сонголт 2) гэсэн хоёр үе шаттайгаар оюутны вебээр хийж баталгаажуулна.
- 9.2. Шинээр элссэн болон шилжин суралцаж буй оюутан хуанлид заасан хугацаанд хичээл сонголт 1 ба 2-ыг хамтад нь хийж баталгаажуулна.
- 9.3. 2 ба түүнээс дээш курсын оюутан сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд “Хичээл сонголт 1”-ээр дараагийн улиралд судлах хичээлийг сонгох ба тухайн улирлын эхэнд сургалтын төлөвлөгөө болон хичээлийн хуваарийг үндэслэн “Хичээл сонголт 2”-ыг хийж баталгаажуулна. Оюутан хичээл сонголт 2 хийхээс өмнө сургалтын төлбөрөө цахимаар төлж баталгаажуулсан байна.
- 9.4. Бакалаврын хөтөлбөрийн оюутны зөвлөх багшийг хаврын улирлын төгсгөлд бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар томилно. Зөвлөх багш нь өөрийн хариуцаж байгаа хөтөлбөрийн оюутнуудыг төгсөх хүртэл сургалт, эрдэм



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

шинжилгээ, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөн тусалж, чиглүүлж ажиллана.

- 9.5. Оюутан хичээл сонголт хийхдээ өөрийн суралцаж байгаа хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг судлах, зөвлөх багш, сургалтын албанаас зөвлөгөө авахаас гадна өөрийн мэдлэг, чадвар, санхүүгийн боломжийг харгалзан төлөвлөлтөө зөв хийсэн байна.
- 9.6. Оюутан үндсэн улиралд дунджаар 15 кредитийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судлах кредитийн дээд хэмжээ 21 байна. Дадлагын хичээлийг энэ ачаалалд тооцохгүй. Өвлийн улиралд судлах кредитийн дээд хэмжээ 3, зуны улиралд 6-аас илүүгүй байна.
- 9.7. Хавсарга, хос, хамтарсан хөтөлбөрөөр суралцаж буй оюутан нэг улиралд 30 хүртэл кредитийн хичээл сонгож болно.
- 9.8. Оюутан биеийн тамирын хичээлээр сонирхсон аль нэг спортын төрлийг сонгон судална. Эрүүл мэндийн хувьд спортын төрөл сонгон суралцах боломжгүй тохиолдолд эмчилгээний биеийн тамирын хичээлийг сонгон судалж болно.
- 9.9. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр “Хичээл сонголт 1”-ээс хоцорсон оюутан тухайн улирлын хичээл сонголт 2 хийгдэх хугацаанд сургалт хариуцсан нэгжид хандан, эсвэл цахим системээр дамжуулан нэмэлт хураамж төлж хичээл сонголт хийнэ.
- 9.10. Оюутны өөрөөс үл хамаарсан нөхцөлөөр эсвэл хүндэтгэн үзэх шалтгаанаар “Хичээл сонголт 2”-т өөрчлөлт оруулж болно.
- 9.11. Оюутан 5-р долоо хоног хүртэл хичээлд суугаагүй тохиолдолд, хичээл зааж байгаа багшийн саналаар эсвэл өөрийн хүсэлтээр хичээл сонголтыг цуцалж болно.
- 9.12. Оюутны сонгосон хичээлийн кредитийг 5-р долоо хоногт багтаан бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 9.13. Оюутан 5-р долоо хоногоос хойш өөрийн хүсэлтээр хичээл сонголтыг цуцлах тохиолдолд хүсэлт гаргасан хугацаанаас өмнөх сургалтын хугацааны төлбөрийг аргачлалын дагуу суутган тооцно.
- 9.14. Оюутны тухайн улиралд хичээл сонголт хийгээгүй тохиолдолд оюутны бүртгэл идэвхгүй төлөвт шилжинэ.

АРАВ. ОЮУТНЫ МЭДЛЭГИЙН ҮНЭЛГЭЭ

- 10.1. Оюутны хичээлээр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг дүгнэх үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, шударга, ил тод байна.
- 10.2. Нэг сургалтын хөтөлбөрт өөр өөр сургалтын хэлбэрээр суралцаж байгаа оюутнуудын мэдлэг, чадвар, хандлагыг ижил зарчмаар дүгнэнэ.
- 10.3. Тухайн хичээлээр оюутны улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ нь хичээлийн явцын болон улирлын шалгалтын оноонос бүрдэнэ. Хичээлийн хөтөлбөрт хичээлийн суралцахуйн үр дүн, сургалтын арга зүй, үнэлгээний аргыг харилцан уялдаатай тодорхойлж үнэлгээний хуваарилалтыг хийсэн байна.
- 10.4. Хичээлийг үнэлгээ нь нийт 100 оноо байх ба явцыг 70 хүртэл, улирлын шалгалтыг 50 хүртэл оноогоор дүгнэнэ. Хичээлийн онцлогоос хамаарч зарим хичээлийг зөвхөн явцын эсвэл улирлын шалгалтаар, 100 хүртэл оноогоор дүгнэж болно. Хичээлийн төрөл, хүргэх хэлбэрээс хамааруулан хүснэгт 10.1-д үзүүлсэн үнэлгээний жишиг аргуудаас сонгон хэрэглэж болно.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

Хүснэгт 10.1. Хичээлийн үнэлгээний жишиг аргууд

Д/Д	Үнэлгээний аргууд	Хичээл			Дадлага	Төслийн хичээл	Дипломын төсөл
		Лекц	Семинар /практик	Лаборатори			
1	Хичээлийн ирц, идэвх оролцоо	√	√	√	√	√	
2	Мэдлэг шалгах асуулт	√	√	√	√	√	
3	Лаборатори, туршилтын ажлын гүйцэтгэл			√	√		
4	Илтгэл, реферат	√	√		√	√	√
5	Бие даалтын ажил, курсын ажил, даалгавар	√	√			√	
6	Тайлан			√	√	√	√
7	Асуудал шийдвэрлэх даалгавар	√	√	√	√	√	√
8	Нөхцөлт бодлого	√	√	√			
9	Бичиг баримт боловсруулалт			√	√	√	√
10	Явцын шалгалт (сорил)	√	√	√		√	
11	Улирлын шалгалт	√	√			√	

- 10.5. Оюутны судалгааны ажлын үр дүн, суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр дотоодын болон олон улсын уралдаан тэмцээн, олимпиад, олон нийтийн ажилд гаргасан амжилтыг үндэслэн харгалзах хичээлийн үнэлгээг шууд тооцож болно.
- 10.6. Явцын болон улирлын шалгалтын нийлбэр 100 хүртэлх оноог хүснэгт 10.2-д үзүүлсний дагуу үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. Үүнд:

Хүснэгт 10.2. Үнэлгээний хүснэгт

Нийт оноо	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний оноо
95-100	A+	4.0
90-94	A	3.7
87-89	B+	3.3
83-86	B	3.0
80-82	B-	2.7
77-79	C+	2.3
73-76	C	2.0
70-72	C-	1.7
65-69	D	1.3
60-64	D-	1.0
0-59	F	0.5
	WF	0

- 10.7. Үсгэн үнэлгээ нь дараах агуулгатай байна. Үүнд:

- 10.7.1. A+ болон A үнэлгээ: Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэд, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтуудыг чадварлаг ашигладаг;



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.7.2. В+, В болон В- үнэлгээ: Дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, тухайн хичээлтэй холбоотой аливаа асуудал шийдвэрлэхдээ ухагдахууныг ашиглах чадвартай;
- 10.7.3. С+, С болон С- үнэлгээ: Тухайн хичээлийн агуулгыг дундаж түвшинд эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахууныг хангалттай ойлгосон, дундаж түвшний асуудлыг шийдвэрлэх чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэй;
- 10.7.4. D, D- үнэлгээ: Дундаж түвшнээс доогуур амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахуунуудыг жигд ойлгоогүй, энгийн хялбар асуудлыг шийдвэрлэх чадвартай, ерөнхийдөө мэдлэг, чадвар, дадал, хандлага дутмаг;
- 10.7.5. F үнэлгээ: Сургалтын үйл ажиллагаанд оролцсон хэдий ч мэдлэг, чадвар, хандлага, дадал хангалтгүй илтгэх дүн;
- 10.7.6. WF үнэлгээ: Сургалтын үйл ажиллагааны тодорхой хэсэгт оролцоогүй улмаас хангалтгүй үнэлгээ авах боломжгүй болсныг илтгэх дүн;
- 10.8. Тухайн хичээлийн ач холбогдлыг харгалзан уг хичээлд авбал зохих дүнгийн доод хязгаарыг зааж сургалтын төлөвлөгөөнд тусгайлан тэмдэглэж (*) болно.

Англи хэлний стандарт шалгалтын үнэлгээ

- 10.9. Оюутан төгсөхдөө Европын олон хэлний стандарт (CEFR)-ын Англи хэлний эзэмшвэл зохих B1 түвшний болзлыг хангасан байна.
- 10.10. Оюутан өөрийн Англи хэлний чадвараа хангалттай гэж үзвэл хуанлид заасан хугацаанд бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид хандан кредит шууд тооцох шалгалт өгч болно.
- 10.11. Англи хэлний олон улсын шалгалтын хүчин төгөлдөр батламжийг үндэслэн тухайн хичээлийг хариуцсан нэгжийн шийдвэрээр “Англи хэлний стандарт шалгалт”-ыг дүйцүүлж болно.
- 10.12. Стандарт шалгалтын үнэлгээг хүснэгт 10.3-д үзүүлсний дагуу ШУТИС-ийн үнэлгээнд дүйцүүлнэ.

Хүснэгт 10.3. Англи хэлний олон улсын стандарт шалгалтын оноо, үнэлгээний дүйцүүлэлт

ШУТИС-ийн үнэлгээ		(CEFR)	Олон улсын стандарт шалгалт				
тоон	Үсгэн	Түвшин	English Score	IELTS	Duolingo	TOEIC	TOEFL IBT
95-100	A+	C2	500-599	8.0-9.0	125-160	990	110-120
		C1		7.5	115-120	855-985	100-109
		B2	367-499	7	105-110	805-850	89-101
		B2		6.5	95-100	755-800	78-88
90-94	A	B1	300-366	6	85-90	700-750	68-77
		B1		5.5	75-80	650-695	60-76
30-89	F-B+	A1-A2	0-299 NA (Not Available)				

- 10.13. Оюутан Европын олон хэлний стандартын Англи хэлний эзэмшвэл зохих B1 түвшнийг хангахын тулд бэлтгэл хичээл судлах ба шалгалтыг хичээл хариуцсан сургууль зохион байгуулна.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06-ны өдрийн A/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.14. В1 түвшний болзол хангаагүй оюутан тухайн улиралдаа дахин шалгалт өгөх эрхтэй бөгөөд хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд багш "NA" тэмдэглэгээг бүртгэнэ.
- 10.15. "NA" тэмдэглэгээ бүхий оюутан суралцах хугацаандаа тухайн хичээлийг дахин сонгож судлах эсвэл дахин шалгалт өгч В1 түвшний болзол заавал хангасан байна.

Үнэлгээний голч дүн, үнэлгээний дундаж оноо

- 10.16. Оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны үнэлгээний голч дүнгээр тодорхойлно.
- 10.17. Үнэлгээний голч дүн(GPA) нь оюутны хичээл бүрийн үсгэн үнэлгээг харгалзах үнэлгээний оноонд шилжүүлэн, тухайн хичээлийн кредитээр үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг кредитийн нийлбэрт харьцуулсан үзүүлэлт бөгөөд дараах томьёогоор тооцно.

$$\text{Үнэлгээний голч дүн (ҮГД)} = \frac{O_1 K_1 + \dots + O_n K_n}{K_1 + \dots + K_n} = \frac{\sum_1^n O_i K_i}{\sum_1^n K_i}$$

i=1, ..., n; O₁, ..., O_n нь 1, ..., n дугаар хичээлд харгалзах үнэлгээний оноо

K₁, ..., K_n нь 1, ..., n дугаар хичээлд харгалзах кредит

- 10.18. Үнэлгээний дундаж оноо нь оюутны хичээл бүрийн нийт оноог харгалзах кредитээр үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг кредитийн нийлбэрт харьцуулсан үзүүлэлт бөгөөд дараах томьёогоор тооцно.

$$\text{Үнэлгээний дундаж оноо (ҮДО)} = \frac{D_1 K_1 + \dots + D_n K_n}{K_1 + \dots + K_n} = \frac{\sum_1^n D_i K_i}{\sum_1^n K_i}$$

i=1, ..., n; D₁, ..., D_n нь 1, ..., n дугаар хичээлд харгалзах нийт оноо

K₁, ..., K_n нь 1, ..., n дугаар хичээлд харгалзах кредит

- 10.19. Оюутан суралцсан хугацааны эсвэл тухайн улирлын үнэлгээний голч дүнгийн түвшин шаардлага хангаж байгаа эсэхээ хянаж, цаашид суралцах арга барилаа төлөвлөнө.
- 10.20. Тухайн улиралд 15-аас багагүй кредит цуглуулсан, улирлын үнэлгээний голч дүн нь 3.60 ба түүнээс дээш амжилт үзүүлсэн оюутны нэрийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын нэрэмжит хуудсанд оруулна. Тухайн улиралд сонгосон хичээлийн аль нэгд WF үнэлгээ эсвэл E тэмдэглээ аваагүй байна.
- 10.21. Улирлын үнэлгээний голч дүн нь 1.00 ба түүнээс доош бол оюутныг "Тухайн улиралд хангалтгүй суралцсан" гэж үзнэ. Хангалтгүй суралцсан оюутны нэрийг "Анхааруулгын хуудас"-нд бичиж сануулна. Оюутны нэр анхааруулгын хуудсанд З улирал бичигдсэн тохиолдолд сурлагаар тэнцээгүй гэж үзэж сургуулиас хасна.
- 10.22. Оюутныг ШУТИС, бүрэлдэхүүн, салбар сургууль, хөтөлбөрөөр нь үнэлгээний голч дүн, дундаж оноогоор эрэмбэлж, үр дүнг хос, хавсарга, солилцооны хөтөлбөрөөр суралцах болон магистрын хичээл судлах, урамшуулал, тэтгэлэг, сургалтын зээлд хамрагдах гол шалгуур болгоно.



ШУТИСийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.23. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж оюутны үнэлгээний голч дүн, дундаж оноог дээд боловсролын нэгдсэн системд улирал бүртгэнэ.
- 10.24. Оюутан баталгаажсан дүнгийн болон бусад тодорхойлолтыг оюутны вебээс цахим хэлбэрээр эсвэл сургалт хариуцсан нэгжээс хэвлэмэл байдлаар авч болно.

Дүнгийн нэмэлт үсгэн тэмдэглэгээ

- 10.25. Оюутны хичээлд оролцсон байдал, шалгалт өгсөн эсэх, дүнгээ ахиулах боломж олгох, кредит шилжүүлэн тооцох зэргийг илтгэх нэмэлт үсгэн тэмдэглэгээг хүснэгт 10.4-т заасны дагуу хэрэглэнэ.

Хүснэгт 10.4. Дүнгийн нэмэлт тэмдэглэгээ

Үсгэн тэмдэглэгээ	Үнэлгээний голч дүн бодоход уг тэмдэглэгээ бүхий дүнг тооцох эсэх	Дүнгийн тодорхойлолтод уг тэмдэглэгээ бичигдэх эсэх	Төгсөлтийн баримт бичигт уг тэмдэглэгээ бичигдэх эсэх
DC	Үгүй	Үгүй	Үгүй
NA	Үгүй	Тийм	Үгүй
WF	Тийм	Тийм	Үгүй
R	Тийм	Тийм	Үгүй
I	Үгүй	Тийм	Үгүй
E	Үгүй	Тийм	Үгүй
CA	Үгүй	Тийм	Үгүй
SP	Үгүй	Тийм	Үгүй
NP	Үгүй	Тийм	Үгүй

DC (DCA Direct Credit Assessment) - Оюутан кредит шууд тооцох шалгалт өгөх:

- 10.26. Оюутан тухайн хичээлийн талаарх мэдлэг, чадвараа хангалттай гэж үзвэл кредит шууд тооцох шалгалт өгч болно. Оюутан нэг улиралд 3 хүртэл хичээлийн кредит шууд тооцох шалгалт өгөх эрхтэй. Сургалтын төлөвлөгөөнд тусгайлан тэмдэглэсэн (*) хичээл болон мэргэших хичээлээр кредит шууд тооцох шалгалт өгөхийг зөвшөөрөхгүй.
- 10.27. Оюутан сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд кредит шууд тооцох шалгалт өгөх хүсэлтээ бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид гаргана. Кредит шууд тооцох шалгалтад орохын өмнө тухайн хичээлийн кредитийн 30 хувийн төлбөрийг төлсөн байна.
- 10.28. Кредит шууд тооцох шалгалтыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж тухайн хичээлийг хариуцсан тэнхимтэй хамтран зохион байгуулна.
- 10.29. Кредит шууд тооцох шалгалтыг 100 хүртэл оноогоор үнэлнэ. Хэрвээ оюутан шалгалтын дунд сэтгэл хангалуун бус байвал тухайн хичээлийг дахин судалж болно.

E (Exam Incomplete By The Student) - Оюутан улирлын шалгалт өгөөгүй:

- 10.30. Оюутан ямар нэг шалтгааны улмаас улирлын шалгалтад ороогүй тохиолдолд багш энэ тэмдэглэгээг тавина.
- 10.31. Е тэмдэглэгээтэй хичээлийн шалгалтыг тухайн хичээлийн кредитийн 30 хувийн төлбөрийг төлж, 4 улирлын дотор нөхөн өгсөн байна. Хэрэв тухайн хугацаанд дүгнүүлээгүй тохиолдолд явцын оноог харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.
- 10.32. Оюутан хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтад ороогүй тохиолдолд нотлох баримтыг үндэслэн төлбөргүйгээр заасан хугацаанд нөхөн өгнө.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.33. Улирал заасан заавал судлах хичээлийн шалгалтыг тэнхмийн саналыг үндэслэн сургалт хариуцсан захирагааны нэгжийн шийдвэрээр зохион байгуулна.

R (Repeating A Course) - Оюутан тухайн хичээлийг дахин судлахаар шийдсэн:

- 10.34. Оюутан тухайн хичээлийн үнэлгээг ахиулж дахин судлах зорилгоор сургалт хариуцсан нэгжид хандсан тохиолдолд R тэмдэглэгээг хэрэглэнэ. R тэмдэглэгээтэй хичээлийг дараах нөхцөлөөр үнэлнэ. Үүнд:

10.34.1. Тухайн хичээлийг дахин шинээр судалсан бол явцын болон улирлын шалгалтын онооны нийлбэрээр;

10.34.2. Өмнө судалсан хичээлийг бүрэн дүгнүүлж, явцын үнэлгээ нь авбал зохих онооны 70 ба түүнээс дээш хувьтай байх тохиолдолд 3 улирлын дотор кредит шууд тооцох шалгалт өгч болно.

10.34.3. Оюутан “R” тэмдэглэгээтэй хичээлийг үнэлүүлж дүнгээ ахиулж чадаагүй тохиолдолд өмнөх үнэлгээг тооцуулж болно.

- 10.35. Оюутан “R” тэмдэглэгээтэй хичээлтэй залгамж холбоо бүхий дараагийн хичээлийг сонгон судлах эрхтэй.

WF (Withdrawal Fail) - Оюутан хичээлийн явцад тухайн хичээлд суралцахаас татгалзсан:

- 10.36. Оюутан сонгосон хичээлдээ суугаагүй, эсвэл лаборатори, дадлага, бие даалтын ажлыг гүйцэтгээгүй зэрэг шалтгаанаар тухайн хичээлийн авбал зохих явцын үнэлгээний 40 ба түүнээс доош хувиар дүгнэгдсэн тохиолдолд энэ тэмдэглэгээг хэрэглэнэ.

I (Incomplete): Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтад ороогүй:

- 10.37. Оюутан хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтад ороогүй бол I тэмдэглэгээг хэрэглэнэ. I тэмдэглэгээтэй хичээлийн шалгалтыг улирлын шалгалтын хугацаанд нөхөн үнэлүүлсэн байна. Энэ хугацаанд багтаж үнэлүүлээгүй тохиолдолд I тэмдэглэгээ нь Е тэмдэглэгээнд шилжинэ.

NA (Final Grade Not Yet Available) Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ:

- 10.38. Оюутны тухайн улиралд сонгон судалж байгаа хичээлийн эцсийн үнэлгээ гарах хүртэл хугацаанд, мөн суралцах хугацаанд заавал үнэлэгдсэн байх хичээлийн зохих үнэлгээг авах хүртэлх хугацаанд NA тэмдэглэгээг тус тус хэрэглэнэ.

CA (Cancelled) Хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээл сонголтыг цуцлах:

- 10.39. Хугацаат цэргийн албанад татагдсан, хязгаарлалт, хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт 2 сараас илүү хугацаагаар байсан, гэнэтийн осолд өртсөн, хүнд өвчний улмаас мэс засал хийлгэсэн зэрэг зайлшгүй шалтгааны үед нотлох баримтыг үндэслэн оюутны бүртгэлийг өөрчилж тухайн улиралд сонгон судалж буй хичээлд CA тэмдэглэгээ хэрэглэнэ. Энэ тэмдэглээ бүхий хичээлийн сургалтын төлбөрийг оюутны хүсэлтийг хэргалзан дахин суралцах хүртэл хадгалах эсвэл суутгалгүйгээр буцаан олгоно.

Шалгалт

- 10.40. Оюутны тухайн хичээлээр эзэмшилсэн суралцахуйн үр дүнг явцын болон улирлын шалгалтаар үнэлнэ.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.40.1. Явцын шалгалтаар хичээлийн явцад оюутны эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц дэвшлийг үнэлэх бөгөөд хичээлийн онцлогобос хамаарч улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.
- 10.40.2. Улирлын шалгалтаар улирлын төгсгөлд оюутны тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварын хүрсэн түвшнийг тогтооно. Мэргэшүүлэх хичээлийн шалгалтыг улирлын шалгалтын хугацаанд тэнхимиин эрхлэгч болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр дахин 1 удаа зохион байгуулж болно.
- 10.41. Багш үнэлгээний шалгуур үзүүлэлт, шалгалтын дэгийг хичээлийн эхэнд оюутнуудад танилцуулсан байна.
- 10.42. Багш удирдамжийн дагуу улирлын шалгалтыг зохион байгуулах ба шалгалтын хуваарийг өөрчлөх тохиолдолд бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид хандана.
- 10.43. Оюутан улирлын шалгалтаас өмнө тухайн хичээлийн явцын үнэлгээ болон улирлын шалгалтын хуваарьтай заавал танилцсан байна.
- 10.44. Багш сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд хичээлийн явцын болон улирлын шалгалтын үнэлгээг удирдлагын мэдээллийн системд бүртгэнэ. Систем нээлттэй байх хугацаанд багш үнэлгээг өөрчилсөн тохиолдолд бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид заавал мэдэгдэнэ.

Гүйцэтгэлийн үнэлгээ

- 10.45. Сургалт хариуцсан захиргааны нэгжээс гаргасан удирдамжийн дагуу бүрэлдэхүүн, салбар сургуулийн хөтөлбөр хариуцсан тэнхим төгсөх оюутны санал асуулгыг, хичээл заасан багш хичээлийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээ, санал асуулгыг улирал бүр зохион байгуулна. Хөтөлбөр хариуцсан тэнхим хичээлийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээ, санал асуулгуудын үр дүнд шинжилгээ хийж, цаашид тасралтгүй сайжруулах төлөвлөгөө бүхий нэгдсэн тайланг сургалт хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.
- 10.46. Оюутан хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, багшийн заасан хичээлийн чанарын үнэлгээг бодитой болгоход дэмжлэг үзүүлж санал асуулгад заавал оролцож асуулгыг бодитой дүгнэх үүрэгтэй.
- 10.47. Сургалт хариуцсан захиргааны нэгж бүрэлдэхүүн, салбар сургуулиудаас ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж шаардлагатай хичээлүүдэд хөтөлбөрийн хороотой хамтран хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулна.
- 10.48. Хөтөлбөрийн хорооноос төлөвлөгөөт ажил байдлаар түүврийн аргаар хичээл сонгон суралцахуйн үр дүнгийн хүрсэн түвшинд хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулж болно.
- 10.49. Сургалт хариуцсан захиргааны нэгжээс хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээр хичээлийн чанарыг хэрхэн сайжруулах санал зөвлөмж боловсруулж хөтөлбөр хариуцсан тэнхим хүргүүлэн, зохион байгуулсан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Хичээлийн үнэлгээний гомдол, саналыг шийдвэрлэх

- 10.50. Оюутан хичээлийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шалгалтын удирдамжид заасан хугацаанд хичээл заасан багшид хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 10.51. Багш оюутны хүсэлтийг хүлээн аваагүй бол бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид хандана.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 10.52. Сургалт хариуцсан нэгж оюутны явцын үнэлгээ, улирлын шалгалтын нотлох баримтыг хянан магадалж сургалт хариуцсан захиргааны нэгжид хандаж шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. ОЮУТНЫ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН

Гадаад, дотоодын их сургуулиас шилжин суралцах:

- 11.1. Шилжин суралцах хүсэлтэй оюутан дараах бичиг баримтыг бүрдүүлэн цахим бүртгэлээр хандана. Үүнд :
- Иргэний үнэмлэх, эсхүл лавлагаа;
 - Суралцсан хугацааны дүнгийн баталгаажсан тодорхойлолт (үнэлгээний голч дүн 2.00-оос дээш байх);
 - Дүнгийн тодорхойлолтын баталгаат орчуулга (гадаадын их сургуулиас шилжин суралцах тохиолдолд);
 - Шилжин суралцах хөтөлбөрийн элсэлтийн шалгалт, босго онооны шаардлагыг хангасан байх (гадаадын их сургуулиас шилжин суралцах бол хамаарахгүй);
- 11.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжийн дарга шилжих хүсэлтэй оюутны бичиг баримттай танилцаж, хөтөлбөр хариуцсан тэнхимиийн эрхлэгчийн саналыг үндэслэн шилжин суралцах зөвшөөрөл олгоно.
- 11.3. Зөвшөөрөл авсан оюутан цахим бүртгэлээр анкет бөглөн, оюутны код авах ба оюутны вебээр суралцах гэрээ байгуулж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжээс хичээл сонголт хийх эрх авна.
- 11.4. Шилжин суралцах хөтөлбөрийн элсэлтийн шалгалт, босго онооны шаардлагыг хангаагүй тохиолдолд оюутанд татгалзсан хариу ёгнэ.

ШУТИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах:

- 11.5. Оюутан дараах шалгуурыг хангасан тохиолдолд хөтөлбөр хооронд шилжин суралцах хүсэлт гаргаж болно. Үүнд:
- 11.5.1. Элсэн орсон хөтөлбөрөөр суралцан 18-аас багагүй кредит цуглувансан байх;
- 11.5.2. Шилжин суралцах хөтөлбөрийн элсэлтийн шалгалт, босго онооны шаардлагыг хангасан байх.
- 11.6. Орон нутаг дахь салбар, харьяа сургуулийн оюутан 2 хичээлийн жил, 2.80 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан тохиолдолд Улаанбаатар хот дах бүрэлдэхүүн сургуульд шилжин суралцах хүсэлт гаргаж болно.
- 11.7. Оюутан бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн хөтөлбөр хооронд шилжин суралцах тохиолдолд шилжүүлэх болон шилжүүлэн авах сургуулийн захирлын саналыг үндэслэн сургалт хариуцсан захиргааны нэгж шийдвэрлэнэ.
- 11.8. Оюутан тухайн сургуулийн хөтөлбөр хооронд шилжин суралцах тохиолдолд 11.5-д заасан шалгуурыг хангасан байх ба тэнхимиийн эрхлэгчийн саналыг үндэслэн сургалт хариуцсан нэгжийн дарга шийдвэрлэнэ.
- 11.9. Шийдвэрийг үндэслэн сургалт хариуцсан нэгж оюутны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийж, код олгох ба сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 11.10. Эчнээ, гарагийн зэрэг бусад төрлийн сургалт ба үндсэн сургалт хооронд оюутан шилжүүлэн суралцуулахгүй. Зөвхөн оюутны тоо багасаж бүлэг бүрдэхгүй болсон тохиолдолд хөтөлбөр хариуцаж байгаа тэнхимиийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

Чөлөө авах, бусад их сургуульд шилжих, сургуулиас чөлөөлөгдхөх:

- 11.11. Сургалтын үйл явцыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон оюутан улирлын эсвэл жилийн чөлөө авах, бусад их сургуульд шилжин суралцах, эсвэл өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдхөх тохиолдолд бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид хандах, эсвэл цахимаар хүсэлт гаргана.
- 11.12. Биеэр ирж хүсэлт гаргасан тохиолдолд сургалт хариуцсан нэгжийн ажилтан оюутанд өргөдлийн маягт олгох ба оюутны хүсэлт гаргасан огноо, суралцсан улирал, нийт кредит, үнэлгээний голч дүн, тухайн улиралд сонгосон кредит, боловсролын зээлийн сангийн зардлаар суралцаж байгаа эсэх мэдээллийг маягтад тэмдэглэнэ.
- 11.13. Оюутан өргөдлийн маягт, тойрох хуудсыг сургалт хариуцсан нэгжийн дарга, хөтөлбөр хариуцсан тэнхимиийн эрхлэгчид танилцуулж зөвшөөрөл авна.
- 11.14. Оюутан тойрох хуудас бүрдүүлсний дараа сургалт хариуцсан нэгжийн ажилтанд хандах ба ажилтан удирдлага, мэдээллийн системд хүсэлт гаргасан огноогоор бүртгэл хийснээр сургалтын төлбөрийн тооцоо бодогдоно.
- 11.15. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн нягтлан бодогч сургалт хариуцсан нэгжийн ажилтны тэмдэглэсэн огноог үндэслэн гарсан төлбөрийн тооцоог хянаж баталгаажуулна.
- 11.16. Оюутан цахим системээр хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлтийг хянах, баталгаажуулах үйл ажиллагаа эрх бүхий оролцогч талуудын зөвшөөрлөөр шийдвэрлэгдэнэ.
- 11.17. Оюутанд чөлөө олгосон, шилжүүлсэн, чөлөөлснийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулах ба тушаалд хичээлийн жил, улирал, он, сар, өдөр, оюутны чөлөөнөөс эргэн ирж үргэлжлүүлэн суралцах хичээлийн жил, улирлыг тодорхой зааж өгнө.
- 11.18. Оюутанд 1 улирлаар эсвэл 1 жилээр чөлөө олгох ба суралцах хугацаандаа авч болох чөлөөний хугацаа нь 3 хичээлийн жилээс хэтрэхгүй байна.
- 11.19. Монгол улс, ШУТИС-ийн нэрийн өмнөөс олон улсын болон дотоодын уралдаан, тэмцээнд оролцох оюутанд нотлох баримтыг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж богино хугацааны чөлөө олгоно. Хүндэтгэх шалтгаанаар оюутан 3 долоо хоног хүртэл хугацаагаар чөлөө авч болох ба энэ тохиолдолд хичээл зааж байгаа багшид бичгээр эсвэл цахимаар хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.
- 11.20. Оюутны чөлөөний хугацаа дуусаж эргэн суралцахдаа хичээл сонголт-2 зохион байгуулагдахаас өмнө бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид хандаж, тухайн улиралд судлах хичээлээ сонгоно. Оюутныг чөлөөнөөс үргэлжлүүлэн суралцуулах шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулна.
- 11.21. Чөлөөний хугацаа дууссан боловч эргэн суралцаагүй оюутны бүртгэл идэвхгүй төлөвт шилжинэ.
- 11.22. Бусад их сургуульд шилжсэн оюутан эргэн суралцах бол 11.1 заалтыг баримтлан шилжин суралцах хүсэлт гаргаж болно.

Сургалтаас чөлөөлөх:

- 11.23. Сургуулийн захиргаанаас дараах тохиолдолд оюутантай байгуулсан суралцах гэрээг цуцалж, сургуулиас хасна. Үүнд:
 - 11.23.1. ШУТИС-ийн дүрэм, журмыг зөрчсөн;



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

11.23.2. Сургалтын явцыг шалтгаангүйгээр орхиж, 4 улирлын турш идэвхгүй төлөвт бүртгэгдсэн;

11.23.3. Оюутны нэр анхааруулгын хуудаст 3 улирал бичигдсэн.

11.24. Оюутан сургуулиас чөлөөлөгдсөнөөс хойш 10 жилийн дотор хүсэлт гаргаж элсэн суралцаж болно. Энэ тохиолдолд өмнө суралцсан хугацааны амжилттай судалсан хичээлийг тухайн элссэн хичээлийн жилд мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөний дагуу дүйцүүлэн тооцож болно.

Оюутны сургалтын төлбөрийн тооцоо хийх аргачлал:

11.25. Оюутны сургалтын төлбөрийн тооцоо нь оюутны сургалтад хамрагдсан хугацааны сургалтын зардал ба үйлчилгээний зардлаас бүрдэнэ.

Оюутны төлбөл зохих төлбөр= A+B

Энд:

A - Оюутны суралцсан хугацааны сургалтын зардал

B - үйлчилгээний зардал

11.25.1. Оюутны суралцсан хугацааны сургалтын зардлыг(A) дараах байдлаар тооцно.

Оюутны нэгж зардал=(Сонгосон кредит×1 кредитийн үнэлгээ)/16

A=Оюутны нэгж зардал×суралцсан долоо хоног

11.25.2. Үйлчилгээний зардал(B)-д оюутны бүртгэл, баталгаажуулалт, бичиг хэрэг хөтлөлт зэрэг зардал багтах ба тухайн хичээлийн жилийн 1 кредитийн үнэлгээний 20%-тай тэнцүү байна. Энэ зардлыг зөвхөн сургалтаас чөлөөлөгдөж байгаа оюутанд тооцно.

11.26. Боловсролын зээлийн сангийн зардлаар суралцаж буй оюутан чөлөө авбал чөлөөний хугацаанд төрөөс олгох санхүүжилтийг түр зогсоно.

11.27. Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг, зээлд хамрагдсан оюутан хөтөлбөр хооронд шилжин суралцах, сургалтын гэрээ цуцлах, сургалтаас чөлөөлөгдхөг тохиолдолд Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.

АРВАН ХОЁР. ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ

- 12.1. Гадаад, дотоодын их сургуулиас шилжин суралцаж байгаа, дипломын, дэд бакалаврын болон бакалаврын боловсролтой оюутан өмнөх сургалтаар судалсан хичээлээ дүйцүүлэн тооцуулах хүсэлтийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжид гаргана.
- 12.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж нь хөтөлбөр хариуцсан тэнхимийн саналын дагуу хичээл дүйцүүлэлтийг хийнэ. Шаардлагатай тохиолдолд тэнхим оюутнаас судалсан хичээлийн агуулга, нэмэлт баримт шаардаж болно.
- 12.3. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгж нь хичээл дүйцүүлэлтийн бичиг баримтыг заасан хугацаанд сургалт хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.
- 12.4. Сургалт хариуцсан захиргааны нэгж нь хичээлийн дүйцүүлэлтийг хичээл сонголтоос өмнө баталгаажуулах ба шаардлагатай тохиолдолд хичээл хариуцсан тэнхимээс тодруулж өөрчлөлт оруулж болно.
- 12.5. Хичээл дүйцүүлэн тооцохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

12.5.1. Хичээлийн агуулга, суралцахуйн үр дүнгийн хувьд:

- Хичээлийн кредитийн зөрүү нь 1-с хэтрэхгүй байх;
- Хичээлийн агуулга нь 70%-аас багагүй хувийн давхцалтай байх;
- Ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн хичээл байх; (ШУТИС-ийн төгсөгч болон хөтөлбөр хоорондын шилжилтэд мэргэшүүлэх хичээлийг дүйцүүлж болно)
- Оюутны судалсан хэд хэдэн хичээлийн нийлбэр кредит болон суралцахуйн үр дүнг тухайн дүйцүүлэх хичээлийн кредит, суралцахуйн үр дүнд нэгтгэн дүйцүүлж болно;
- Оюутны судалсан нэг хичээл нь хэд хэдэн хичээлийн кредит, суралцахуйн үр дүнг хангасан бол тэдгээр хичээлтэй дүйцүүлэн тооцож болно.

12.5.2. Хичээлийн үнэлгээний хувьд:

- Үнэлгээг тооцохдоо үнэлгээний нийт оноонос дүйцүүлэх;
- F буюу хангалтгүй, Е үнэлгээтэй хичээлийг дүйцүүлэхгүй;
- Гадаадын их сургууль, коллежийн хичээлийг дүйцүүлэн тооцохдоо боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан аргачлалыг ашиглах;
- “Тооцов” үнэлгээтэй хичээлийн үнэлгээг тухайн сургуулийн дүнгийн шатлалын тухай албан ёсны тайлбарт үндэслэн дүйцүүлэх.

- Төрийн өмчийн 6 их сургууль хооронд байгуулсан хичээл солилцооны гэрээний дагуу оюутан хичээл судалсан тохиолдолд холбогдох журмын дагуу дүйцүүлэн тооцно.
- ШУТИС-ийн харьяа ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдан зарим хичээлийг бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн хичээлтэй дүйцүүлэн тооцно.
- ШУТИС-ийн зэргийн бус сургалтаар судалсан хичээлийг бакалаврын хөтөлбөрт элссэн тохиолдолд дүйцүүлэн тооцно.
- Хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их сургуульд оюутан солилцооны хөтөлбөрөөр судалсан хичээлийг бакалаврын хөтөлбөрт дүйцүүлэн тооцно.
- Олон улсын шалгалтын хүчинтэй батламжийг үндэслэн тухайн гадаад хэлний хичээлийг хариуцсан тэнхимиийн саналаар олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрдөг шалгалтын үнэлгээг гадаад хэлний хөтөлбөрт 45 хүртэл кредитийн хичээлд, бусад хөтөлбөрийн ерөнхий суурийн ижил чиглэлийн хичээлтэй дүйцүүлэн тооцож болно.
- Дотоод, гадаадын их сургууль хооронд шилжин суралцагчийн өмнө судалсан хичээлүүдээс бакалаврын хөтөлбөрт 45 хүртэл кредитийн хичээлийг дүйцүүлэх ба дэлхийн шилдэг 1000-д эрэмбэлэгдсэн сургуульд судалсан хичээлийг дүйцүүлэх тохиолдолд дээрх хязгаарлалтыг мөрдөхгүй.
- Техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр бакалаврын хөтөлбөрт суралцах тохиолдолд 60 хүртэл кредитийн хичээлийг дүйцүүлнэ.
- Дэд бакалаврын зэрэгтэй төгсөгч (коосэн хамаарна) мэргэжлийн чиглэлээр бакалаврын зэргийн хөтөлбөрт суралцах тохиолдолд 90 хүртэлх кредитийн хичээл дүйцүүлнэ.



ШУТИС-ийн ректорын 2025 оны 06 дугаар сарын
06 -ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралт

- 12.14. Бакалаврын боловсролтой иргэн ижил түвшний хөтөлбөрт дахин элсэн суралцах тохиолдолд ерөнхий суурийн агуулгыг бүрэн хангасанд тооцож, кредитийг суралцах хөтөлбөрийн ерөнхий суурийн кредитийн нийлбэрээр тооцно. Мэргэжлийн суурь ба мэргэших хичээлийн хувьд хөтөлбөр хариуцсан тэнхимийн саналд үндэслэн дүйцүүлэн тооцно.
- 12.15. Гадаадын их сургуультай байгуулсан гэрээний дагуу хамтарсан хөтөлбөрөөр гадаадад суралцаж төгссөн болон эргэн ирж суралцаж буй оюутны судалсан хичээл, кредит, үнэлгээг дүйцүүлэн тооцно.
- 12.16. Дотоод, гадаадын их сургуулийн оюутан, бусад их сургуульд зэргийн бус сургалтаар хичээл судалсан иргэн ШУТИС-д элсэн суралцах тохиолдолд өмнө судалсан хичээлийг дүйцүүлэх эсэх асуудлыг тэнхимийн саналыг үндэслэн сургалт хариуцсан захиргааны нэгж шийдвэрлэнэ.
- 12.17. Оюутан дүйцүүлэн тооцуулсан кредит бүрд тухайн хичээлийн жилийн 1 кредитийн үнэлгээний 20 хувьтай тэнцэх хураамжийг төлнө. Энэ заалт нь 12.6, 12.7, 12.8, 12.15 заалт болон ШУТИС төгсөгчид хамаarahгүй.

АРВАН ГУРАВ. ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 13.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан нийтлэг журам, шаардлагад нийцүүлэн төгсөлтийн журмыг сургалт хариуцсан захиргааны нэгж боловсруулж, батлуулна.
- 13.2. "ШУТИС-ийн бакалаврын төгсөлтийн журам"-ыг баримтлан дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрийн төгсөлтийн үйл ажиллагааг тухайн хичээлийн жилийн намар, хаврын улиралд 2 удаа зохион байгуулна.

-----оо-----